

КОЙКА-гийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө (СР) - Монгол улс-

2019. 6.



Гарчиг

I . Хөгжлийн өнөөгийн байдал	3
1. Улсын хөгжлийн төлөв	
2. Хөгжлийн өнөөгийн байдал	
А. Монгол улсын хөгжлийн бодлого болон стратеги	
Б. Түншлэлийн хамтын ажиллагааны нөхцөл байдал	
3. 2019 оны хөгжлийн чиг хандлага	
А. ОУВС-ын 'Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр' хэрэгжиж байгаа	
Б. 2020 оны УИХ-ын сонгууль	
В. Онцлох хөгжлийн асуудал	
II . БНСУ-ын Засгийн газрын хөгжлийн бодлого болон нөхцөл байдал	9
1. Гадаад бодлого	
А. Дипломат/Хөгжил	
Б. Худалдаа/Нийгэм	
В. Ерөнхий сайдын албан ёсны айлчлалын үр дүн	
2. CPS(үндэсний хөгжлийн төлөвлөгөө) дэмжлэгийн төлөвлөгөө болон үр дүнгийн шинжилгээ	
А. CPS дэмжлэгийн төлөвлөгөө	
Б. Монгол улсад дэмжлэг үзүүлэх байдал	
В. KOICA төслийн үр дүн	
III . KOICA дэмжлэгийн стратеги	17
1. SWOT шинжилгээ болон гүйцэтгэх хөтөлбөр	
2. Гүйцэтгэх хөтөлбөр (outcome/output үзүүлэлт орсон)	

I. Улсын хөгжлийн өнөөгийн байдал

1. Улсын төлөв байдал

- Албан ёсны улсын нэр : Монгол(Mongolia)
- Хот : Улаанбаатар Ulaanbaatar (хүн ам: 1,3 сая),
- Талбайн хэмжээ : 156.7 сая км²
- Цаг уур : Хуурай, хүйтэн уур амьсгалтай (жилийн дундаж -2.9°C)
- Хүн ам : 3 сая 240 мянга / Улаанбаатар хотод 1 сая 300 мянга(2019.2-р сарын байдлаар)
- Үндэстэн : Халх(90%), Казак(5.9%) Буриад(2%) гэх мэт 17 үндэстэн
- Суурин хот : Эрдэнэт(Erdenet), Дархан(Darkhan), Чойбалсан(Choibalsan) г.м
- Хэл : Монгол хэл(90%), Казак, Орос
- Шашин : Буддизм(80%), Ислам(5%), Католик(2%)
- Засгийн газар : Ардчилсан бүгд найрамх улс
- Төрийн тэргүүн : Халтмаа Баттулга(Khaltmaa Battulga) 4 жилийн хугацаатай, дахин томилогдох боломжтой, 2017 оны 7-р сарын 9-нд сонгогдсон
- Хууль эрх зүй : Улсын Их хурал
- Нам : Улсын Их хурлын гишүүдийн суудал 76. МАН(64 суудал), Ардчилсан нам(9 суудал), МАХН(1 суудал), Бие даасан(1 суудал), 1 суудал нь нөхөн сонгуулиар сонгогдоно.
- Цагийн зөрүү : БНСУ-с 1 цагаар хоцорно.
- Эдийн засгийн үзүүлэлт : •ДНБ 13 тэрбум 140 сая ам доллар (•1хүнд ногдох ДНБ 3,877 ам доллар, •ДНБ өсөлтийн төвшин 6.9%, •Инфляци 8.1%), •ЗГ-ын төсөв(орлого : 9 их наяд 234 тэрбум 900 сая төгрөг / Зардал : 9 их наяд 223 тэрбум 400 сая төгрөг), •Худалдаа : 12 тэрбум 880 сая ам доллар (Экспорт : 7 тэрбум 100 сая ам доллар (нүүрс, газрын тос, төмөр, зэс), Импорт : 58 тэрбум 700 сая ам доллар(Нефтийн бүтээгдэхүүн, хүнд тоног төхөөрөмж, автомашин), Валютын ханш\$=2,640MNT(2019.6), • Гол нөөц : Зэс, нүүрс, жонш, молибден, вольфарм, цайр, газрын тос гэх мэт (дэлхийд газрын баялагаараа 10 улс дотор орно), • Дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл : Үйлчилгээ(20.4%), Барилга, үйлдвэрлэл(34%), газар тариалан, мал аж ахуй(10.7%), Бусад(34.9%), • Гадаад валютын нөөц : 35 тэрбум 400 сая ам доллар
- Хоёр улсын иргэдийн харилцааны төвшин(2018) : БНСУ-д зорчсон Монгол иргэдийн тоо 118,800, Монгол улсад зочилсон БНСУ-ын иргэдийн тоо 84,200 / Солонгос дахь Монгол иргэдийн тоо : 46,300, Монгол дахь Солонгос иргэдийн тоо(2018) : 2,200

Ангилал	1хүнд ноогдох GNI	HDI	Ядуурлын төвшин	Жендэрийн тэгш байдлын индекс
	XXXX	0.741(92-т)	29.6%	1.023
Ангилал	Засаглалын индекс	Бичиг үсэг тайлагдаагүй	Нялхсын эндэгдэл	Цахим засгийн газрын индекс
	64	14%	27.3/1000 хүн	0.51

2. Хөгжлийн өнөөгийн байдал

А. Монгол улсын хөгжлийн бодлого болон стратеги

- Монгол улсын засгийн газраас урт хугацааны хөгжлийн бодлогыг (2015-2040) болон тогтвортой хөгжлийн зорилт(SDV) 2030-ийг баталж хэрэгжүүлж байна.

SDV зорилго	Гол агуулга
1. 1 хүнд ногдох GNI 17,500\$	<ul style="list-style-type: none"> ① Бүтээмжийг сайжруулах ② Нөөцийн үр ашгийг дээшлүүлэх ③ Эдийн засгийн үр ашиг, үр дүнг дээшлүүлэх
2. Жил бүр эдийн засгийн өсөлтийн төвшинг 6.6%-тай байлгах	<ul style="list-style-type: none"> ① Төсвийн алдагдлыг бууруулах ② Худалдааны алдагдлыг бууруулах ③ Санхүүгийн тогтвортой байдлыг дээшлүүлэх ④ Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх
3. Орлогын тэгш бус байдлыг бууруулах	<ul style="list-style-type: none"> ① Боловсролын системийг боловсронгуй болгох ② Хөдөлмөрийн оролцооны тэгш байдлыг хангах ③ Хөдөлмөрийн зах зээлийн тогтолцоог бий болгох
4. Амьдрах нөхцөлийг сайжруулах, эко системийн	<ul style="list-style-type: none"> ① Халамжийн үйлчилгээ болон ядуурлыг бууруулах

тэнцвэрийг хадгалах	② Технологийн дэмжлэг үзүүлэх ③ Хог хаягдлын менежментийн удирдлага ④ Байгаль орчинд ээлтэй бодлого
5. Мэргэжлийн, тогтвортой оролцооны засаглалыг бий болгох	① Цахим засаглалыг өргөжүүлэн шударга ёс, ёс суртахуун, хариуцлагыг нэмэгдүүлэх ② Эрх мэдлийг хязгаарлах ③ Хуул ④ Авилгын эсрэг үйл ажиллагаа

○ Тогтвортой хөгжлийн зорилтот тулгуурлан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2016-2020)-ийг боловсруулан 2020 он хүртэл ▲ Макро эдийн засгийн бодлого, ▲ Эдийн засгийн өсөлтөд нөлөөлж буй гол салбарын хөгжлийн бодлого, ▲ Орон нутгийн газар тариалангийн хөгжил, байгаль орчны бодлого, ▲ Хүний хөгжил, нийгмийн бодлого, ▲ Засаг захиргааны хууль эрх зүйг сайжруулж, гадаад харилцаа-батлан хамгаалахын бодлого гэх мэт нийгэм эдийн засгийн хөгжлийн 20 зорилтот чиглэлээр 118 бодлогыг дэвшүүлсэн

* Уг зорилтыг хэрэгжүүлэхэд нийт 10 их наяд 216 тэрбум 300 сая төгрөгийн санхүүжилт хэрэгтэйгээс, Засгийн газраас (1 их наяд 325 тэрбум 500 сая), гадаадын эх үүсвэр(2 их наяд 111 тэр бум), Төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт(6 их наяд 174 тэрбум 200 сая), бусад хөрөнгө оруулалт(604 тэрбум 700 сая)-ийг бүрдүүлэн хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй.

* Монгол улсын Засгийн газар, 2016~2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 50.5% хэрэгжүүлсэн(2019 оны 3-р сарын байдлаар)

Б. Түншлэлийн хамтын ажиллагааны нөхцөл байдал

□ Гадаад тусламжийн бодлого болон зээл, буцалтгүй тусламж, хөгжлийн албан ёсны тусламж(ODA)-ийн төслийг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газар(Development Financing Department)-аас хариуцдаг

○ Монгол улсад гадаадын тусламж нь улсын нийт төсвийн 17% эзэлдэг бөгөөд энэ нь үндэсний эдийн засагт чухал хувь нэмэр оруулдаг боловч гадны тусламжийн менежментийн тогтолцоо бүрдээгүй байна.

○ Монгол улсын Сангийн яам нь Азийн хөгжлийн банк(ADB)-ны тусламжтайгаар

2017 онд 'Монгол улсын хөгжлийн хамтын ажиллагааны бодлого' болон

'Гадаад тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журамж(ЗГ-ын 176-р тогтоол) боловсруулан гаргасан боловч энэ нь хандивлагч байгууллагуудын үйл ажиллагаанд нийцтэй бус байсан учир ихэнх хандивлагч байгууллагууд эсэргүүцлээ илэрхийлсний улмаар хараахан хэрэгжиж эхлээгүй байна.

3. 2019 оны хөгжлийн чиг хандлага болон гол асуудлууд

А. ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр

□ Тогтвортой, хүртээмжтэй өсөлтийн үндэс суурийг тавих үүднээс ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн.

- Төсвийн бодлогыг шинэчлэх (ЗГ-ын өр, төсвийн алдагдал, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн сахилга батыг сайжруулах г.м), Төв банкны хараат бус бие даасан байдал, санхүүгийн салбарыг бэхжүүлэх (Арилжааны банкуудын өөрийн хөрөнгийн хэмжээ ба актив чанарын үнэлгээ хийх, чанаргүй зээлийн хэмжээг бууруулах г.м), эдийн засгийг төрөлжүүлэх, хүртээмжтэй өсөлтийг дэмжих, нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн халамжийн тогтолцоо (ялангуяа эрүүл мэнд, боловсролын салбар)-г шинэчлэх

* ОУВС-гийн хөтөлбөрөөр нийт 5.5 тэрбум ам.долларын санхүүжилт хийгдэхээс БНСУ 500 сая ам.доллар, Турк 300 сая ам.доллар, Япон 850 сая ам.доллар тус тус дэмжлэг үзүүлнэ.

- ОУВС-гийн үнэлгээгээр хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын өрийн хэмжээ буурч, валютын ханш тогтворжиж байгаа гэсэн дүгнэлт (2018 онд эдийн засгийн өсөлт 6.2%) гарсан хэдий ч Монгол улсын Засгийн газар төсвийн зарцуулалтыг танах бодлогоо үргэлжлүүлсээр байна.

- Мөн, хэт их уул уурхайд төвлөрсөн аж үйлдвэрийн салбарын бүтцийг шинэчлэх, санхүүгийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах шаардлагатай. Эдийн засгийн салбар дах аж үйлдвэрийн бүтцийг нэмэгдүүлж, төрөлжүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах механизм, тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай.

* ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд ▲2019 оны 4-р сард арилжааны банкны өөрийн хөрөнгийн үнэлгээгээр Капитал банкны чанаргүй зээлийн хувь хэмжээ өндөр, өөрийн хөрөнгө хүрэлцээгүй гэсэн дүгнэлт гарч уг

банкны үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авсан. ▲Хөрөнгийн зах зээлийн ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор мэдээлэл тархалтын тусгай стандарт(SDDS) нэвтрүүлэх шийдвэр гаргасан. ▲2019 оны 5-р сард улс төржилтөөс шалтгаалан шатахууны үнэд нөлөөлдөг нөлөө, шатахууны үнийн огцом өсөлтөөс сэргийлэх зорилгоор Шатахууны үнийг автоматаар тогтоох механизм нэвтрүүлэхээр болсон. Энэ мэтчилэн

санхүүгийн секторт макро эдийн засгийн тогтвортой тогтолцоог бэхжүүлэх арга хэмжээ хэрэгжүүлж байна.

Б. 2020 оны УИХ-ын сонгуулийн үр дүнгээс хамаарч үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хөгжлийн албан ёсны тусламжийн талаар баримталдаг стратеги өөрчлөгдөх магадлалтай.

- Улс төрийн байдал 2019 онд тогтворжсон боловч 2020 онд УИХ-ын сонгууль, 2021 онд ерөнхийлөгчийн сонгууль болох учир цаашид засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд орох өөрчлөлтөд анхаарал тавих шаардлагатай

* 2012 оны УИХ-ын сонгуулийн дараа гадаадын зээл, тусламжийн асуудал хариуцдаг байгууллагаар Эдийн засгийн хөгжлийн яам шинээр байгуулагдах зэргээр Засгийн газрын яам, агентлагуудын бүтэц зохион байгуулалтыг өөрчилсөн хэдий ч тодорхой үр дүнд хүрч чадаагүй. 2016 оны УИХ-ын сонгуулийн дараа Эдийн засгийн хөгжлийн яам татан буугдаж, зээл тусламжийн асуудлыг Сангийн яам хариуцахаар эргүүлэн шилжүүлсэн.

- 2020 оны УИХ-ын сонгуулийн дараа эрх баригч хүчин солигдох тохиолдолд үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөгөөнд орох өөрчлөлт, ХАЁТ-ын хөтөлбөр хэрэгжүүлэх чиг хандлагыг дахин хянаж үзэх магадлалтай ба, ХАЁТ-ын хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангах арга замыг бүрдүүлэх шаардлагатай.

В. Авлигыг арилгахын тулд шударга, ил тод засаглалын тогтолцоог бий болгох шаардлагатай

- Засаглалын харилцан тэнцвэртэй байдлыг хангах, авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх
 - Монгол улс засаглалын харилцан тэнцвэрт байдлыг хангахын тулд 2019 онд УИХ-ын намрын чуулганаар үндсэн хуулийн өөрчлөлтийг хэлэлцэнэ. Үндсэн хуульд оруулах гол өөрчлөлтүүд нь УИХ болон Засгийн газрын харилцан эрх мэдлийн тэнцвэрт байдлыг хангах, Ерөнхийлөгчийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, Шүүхийн улс төрөөс ангид бие даасан байдал, мэргэшсэн байдлыг бэхжүүлэх, Шударга, ёс зүйтэй, хариуцлагатай засаглалыг төлөвшүүлэх зэрэг юм.
 - Мөн түүнчлэн Прокурорын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар зэрэг хууль, шүүхийн байгууллагын удирдлагууд тодорхой хэсэг бүлэг хүмүүсийн хууль бус үйлдлийг нуун далдалсан асуудлаас хамаарч улс төрийн хүрээн дэх хээл хахууль, авлигыг таслан зогсоох зорилгоор 2019 оны 3-р сард Авлигын эсрэг хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.
 - Транспэрэнси Интернэшнл байгууллагаас Монгол улсын Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн үнэлгээний дүгнэлтээс үзвэл

Авлигтай тэмцэх газрын үйл ажиллагаанд нөлөөлөх хөндлөнгийн нөлөөлөл 59%-тай гарсан нь авлигтай тууштай, үр дүнтэй тэмцэх үзүүлэлт доогуур байна гэсэн дүгнэлт гарсан.

- Дээрх нөхцөл байдлаас харахад монголд харилцан тэнцвэртэй, ил тод засаглалын тогтолцоог бүрдүүлэх шаардлага нэн их байна.

Г. Хөгжлийн гол асуудлууд ба чиг хандлага

- **(Эдийн засгийн өсөлт)** Монгол улсын нэг хүнд ногдох ДНБ 1991 оноос 2017 онд 2 дахин нэмэгдсэн боловч эдийн засгийн өсөлт тогтворгүй хэвээр байна. ОУВС-гийн хөтөлбөр хэрэгжсэнээр 2018 онд эдийн засгийн өсөлт 6.2%, 2019 онд 7.1% байх төсөөлөлтэй байна.

* Харин 2018 оны байдлаар нэг хүнд ногдох ҮНО(үндэсний нийт орлого) 11,420 ам.доллар болж орлогын төвшингээр LMIC(дундаас доогуур орлоготой орон)-с UMIC(дундаас дээгүүр орлоготой орон) ангилалд шилжсэн хэдий ч эдийн засгийн хувьд гадаад хүчин зүйлсийн өөрчлөлтөд эмзэг бүтэцтэй учир цаашид анхаарч ажиглах шаардлагатай.

- **(Аж үйлдвэрийн салбарын бүтэц)** Уул уурхайн салбарын ДНБ-д эзлэх хувь(2017 онд 21.9%) өндөр хэвээр байгаа бөгөөд, ХАА-н салбарын аж үйлдвэрт эзлэх хувь багассан хэдий ч бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь өсч байна. Хятад улсын хөнгөн үйлдвэр тэлэн хөгжиж буйн нөлөөгөөр Монголын хөнгөн үйлдвэрийн салбар улам хумигдах төлөвтэй байна.

- **(Ядуурал, тэгш бус байдал)** Монгол улсын ядуурлын төвшин өнгөрсөн 2010 оны байдлаар 38.8% байсан бол 2016 онд 29.6% болж ихээхэн буурсан боловч хүн амын 1/3 нь ядуу нөхцөлд амьдарч байна. Мөн, Gini индексийн үзүүлэлт 30~35%-тай гарсан ба, орлогын тэгш бус байдалд онц өөрчлөлт ороогүй.

- **(Нийгмийн халамж)** Сүүлийн үед нийгмийн халамжийн бодлого хөтөлбөрийг чангатгаснаар нийгмийн халамжийн зардлын ДНБ-д эзлэх хувь харьцангуй өндөр болсон. 2012 оны эдийн засгийн хямралаас хойш нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаа алдагдалтай явагдаж ДНБ-д эзлэх хувь 0.86(2012 он) байснаас 1.61(2015 он), 1.23(2017 он) болж өссөн. 2017 оны байдлаар нийт ажиллагсад(1.4 сая)-ын дөнгөж 70%(1.27 сая) орчим хувь нь нийгмийн даатгалын шимтгэл төлж байв.

- **(Хөдөлмөрийн зах зээл)** Ажилгүйдлийн төвшин 2018 онд өмнөх онтой харьцуулахад 0.3% өссөн. Үүнд ажилгүйчүүдийн 52.9% нь эмэгтэй,

Улаанбаатар 35.3%-ыг эзэлж байна. Хөдөлмөрийн оролцооны хувьд эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүд ажлын байртай болоход багагүй хугацаа зарцуулагддаг ба, цалин хөлсгүй ажиллах, хүүхэд асрах, ажлын байрны олдоц муу гэх зэрэг таагүй нөхцөлтэй тулгардаг. Эмэгтэйчүүдийн хувьд 2017 оны байдлаар мэргэжлийн боловсролын сургууль(20,500 хүн)-тай харьцуулахад их дээд сургууль(29,164 хүн)-д суралцагчийн тоо их, шинжлэх ухаан, технологи, инженерчлэл(STEM 19.7%)-тэй харьцуулахад хүмүүнлэгийн ухаан(47.3%)-ы салбарт илүү их суралцдаг учир ажлын байранд бодитоор хэрэг болох технологийн ур чадвар дутмаг болох нь статистик судалгааны дүнгээр гарсан.

□ **(Боловсрол)** Оюутнуудад олгодог тэтгэмжийг зогсоох тохиолдолд мэргэжлийн боловсролын сургуульд суралцагчийн тоо буурдаг(2014 онд 178 мянга → 2018 онд 157 мянга) болох нь ажиглагдсан ба мэргэжлийн боловсролын сургуульд суралцагч болон төгсөгчдийн ажлын байртай болох нь илэрхий нэмэгдсэн(2007 онд 8% байснаас 2017 онд 27%).

□ **(Эрүүл мэнд)** Амьсгалын эрхтэн тогтолцооны доголдол, хорт хавдар, халдварт бус өвчин, таргалалт, илүүдэл жин зэрэг өвчний эмчилгээ үйлчилгээний зардал өндөр үзүүлэлттэй гарсан. Агаар, ус, хөрсний бохирдлын улмаар халдварт өвчин ихсэх хандлагатай байна. Мөн, эрүүл мэндийн зардлын өрхийн хэрэглээний зардалд эзлэх хувь хэмжээ өсөх шинжтэй байна.

II. БНСУ-ын засгийн газрын хөгжлийн бодлого болон өнөөгийн байдал

1. Гадаад харилцаан бодлого

A. Гадаад харилцаа/хөгжил

□ Евроазид хөл тавих түшиц газраар дамжуулан БНСУ-ын эдийн засгийн шинэ өсөлтийн хөдөлгүүрийг бий болгож, Солонгосын хойгийн аюулгүй байдлын төлөө ерөнхийлөгчийн удирдлага доорх Умард эдийн засгийн хамтын ажиллагааны хороогоор дамжуулан “Шинэ умардын бодлого”-ыг хэрэгжүүлэх.

- 9-Bridge бодлогоор хийн түлш, төмөр зам, усан зам, эрчим хүч, хойд мөсөн далайн зам, усан онгоц үйлдвэрлэл, газар тариалан, загасны аж ахуй, ажлын байр зэрэг 9 салбарт хамтын ажиллагааны төслийг хэрэгжүүлж байна.(Монгол улсын хувьд төмөр зам, эрчим хүчний салбарт хамтран ажиллаж байна.)
 - (Төмөр зам) Транс-Сибирийн Төмөр зам(TSR)-аар дамжуулан тээврийн зардлыг хэмнэх болон Солонгосын хойгийн төмөр зам(TKR)-тай холбох
 - (Эрчим хүч) Сэргээгдэх эрчим хүчийг ашиглан Зүүн хойд Азийн сүлжээг бий болгож нэгдсэн эрчим хүчийг холбох, хуваалцах

- Төв хэсэг(Төв Ази, Монгол)-ийн стратеги: Газрын баялгийг хөгжүүлэх, дэд бүтцийн салбарыг голчлон төрөл бүрийн салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх.
 - Өсөх магадлалтай томоохон газрын баялгийг хөгжүүлэх, дэд бүтцийн хамтын ажиллагааг сайжруулах
 - Солонгос улсын давуу тал болох үйлдвэрлэл, газар тариалан болон мэдээлэл холбооны салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх
 - Засгийн газрын зөвлөлөөр дамжуулан хувийн хэвшлийг дэмжих, засгийн газрын хамтын ажиллагааг бэхжүүлэх

- БНСУ-ын гадаадын зээл, тусламжийн 2-р гол түнш улсын CPS(2016-2020) хэрэгжүүлэлт
 - 2016-2017 оны хооронд жилийн дунджаар 32сая 350мянган доллар орчмын буцалттай, буцалтгүй тусламжийг үзүүлсэн.
 - Хамтран ажиллах гол салбар : Төрийн захиргаа, цэвэр ус, эрүүл мэнд, ариун цэвэр, сургалт, зам тээвэр

- 2018.01-р сард EDCF-ийн дэд сайдын 2-р FA(2018-2021/700сая доллар) хэлэлцээрийг хийснээр агаарын бохирдлыг бууруулах төсөл гэх мэт хамтран ажиллах хүрээг өргөжүүлэх
 - 10 аймагт дулааны цахилгаан станц сайжруулах төсөл(148сая 720 мянган доллар)
 - Агаарын бохирдлыг сайжруулах хөтөлбөр(60сая доллар)
 - Нийтийн орон сууц барих төсөл(батлагдаагүй байгаа) гэх мэт

Б. Гадаад худалдаа/нийгэм

- МУ-ын эдийн засгийн сэргэн мандалтад урьдчилан ирээдүйтэй бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх, цаашлаад МУ-ын гадаад худалдааны гуравдагч орон болох зорилготой(Солонгос улс нь МУ-ын гадаад худалдааны дөрөв дэх орон бөгөөд 2018 оны 7-р сарын хувьд өмнөх онтой харьцуулахад 30.6%-аар өссөн)
 - Худалдан авах чадвар нэмэгдэх тусам уул уурхай, Солонгосын соёл, томоохон дэлгүүрийн салбар нээх, эмийн бүтээгдэхүүн болон эрүүл мэндийн үйлчилгээ, газар тариалангийн тоног төхөөрөмж гэх мэт зүйлүүд мөн адил хөгжинө.
- Солонгос улсыг зорьж буй Монголчуудын тоо нэг жилд 46,300 хүн бөгөөд хоёр улсын соёлын харилцааг дэлгэрүүлж байна.
 - Хоёр улсын агаарын тээврийн тоо, чиглэл нэмэгдсэнээр хоорондын харилцаа илүү өргөжиж байна.

В. Ерөнхий сайдын айлчлал(2019.3.25~3.27)-ын үеэр хэлэлцсэн хөгжлийн хамтын ажиллагаа

- (Шинэ умардын бодлого) Солонгос улсын ‘Шинэ умардын бодлого’-ыг танилцуулж, Зүүн хойд азийн нэгдсэн сүлжээ, Зүүн азийг төмөр замаар холбох ажлын хамтын ажиллагааг өргөжүүлэх.
- (Байгаль орчин) МУ-ын агаарын бохирдлыг сайжруулах тал дээр үргэлжлүүлэн хамтран ажиллах.
- (Эрүүл мэнд) МУ-ын эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг БНСУ-д сургалтанд хамруулах, тус улсад эмчлүүлсэн Монгол өвчтөний эмчилгээг үргэлжлүүлэх гэх мэт эрүүл мэндийн төсөл хөтөлбөрийг өргөжүүлэх.

2. CPS дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө ба гүйцэтгэлийн дүн шинжилгээ

А. CPS(2016-2020) дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө

- (Хамтын ажиллагааны голлох салбар) Төрийн захиргаа, Усны нөөцийн менежмент ба эрүүл ахуй, Боловсрол, Зам тээвэр

Боловсрол	Дээд ба бүрэн дунд боловсрол, техник мэргэжлийн боловсролын орчин нөхцөлийг сайжруулах, эрх тэгш боловсрол эзэмших боломжоор хангах
Усны нөөцийн менежмент ба эрүүл ахуй	<ul style="list-style-type: none"> Халдварт бус өвчин ба сэтгэгдэд нөлөөлөх бодисод хориг тавих ба түүнээс урьдчилан сэргийлэх Цэвэр ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх ба чадавхыг бэхжүүлэх
Төрийн захиргаа	<ul style="list-style-type: none"> Цахим засаглалыг хөгжүүлснээр төрийн захиргааны ил тод байдал ба үр ашгийг нэмэгдүүлэх Төрийн албан хаагчдыг сонгон шалгаруулах ба боловсролын тогтолцоог сайжруулснаар захиргааны үр ашгийг дээшлүүлэх
Зам тээвэр	Ачаа тээвэр, ложистикийн дэд бүтцийг өргөжүүлэх ба удирдахад шаардагдах чадавхыг бэхжүүлэх

Б. МУ-д дэмжлэг үзүүлсэн байдал

1) ДАС гишүүн орон ОДА дэмжлэгийн байдал

- ДАС гишүүн орны хувьд МУ-ын нийт тусламжийн төвшингөөр 2017 оны байдлаар ойролцоогоор 590 сая ам.долларт хүрч 5 жилийн хугацаанд 61 хувиар өссөн байна.

2013	2014	2015	2016	2017
362.72	224.69	196.67	289.45	590.57

Эх сурвалж : OECD.Stat, (2019)


- (Голлох тусламжийн салбар) МУ сүүлийн 5 жилийн хугацаанд нийгэм, эдийн засгийн дэд бүтэц ба үйлчилгээний салбарын тусламж хамгийн өндөр хувийг эзэлсэн бөгөөд түүний дараа зам тээвэр, харилцаа холбоо, боловсрол, үйлдвэрлэл, эрчим хүчний салбар орж байна.

Ангилал	2013	2014	2015	2016	2017	Дундаж
(100) Нийгмийн дэд бүтэц ба үйлчилгээ	122.32	136.23	152.96	93.32	104.19	121.804
(110) Боловсрол	56.46	107.48	28.17	60.63	50.36	60.62
(140) Усан хангамж, эрүүл ахуй	2.75	1.31	7.11	2.84	14.52	5.706

(200)Эдийн засгийн дүгнэлт ба үйнигээ	54.72	7.87	312.42	113.63	21.56	102.04
(230) Эрчим хүч	45.21	1.40	1.84	73.92	16.09	27.692
(215) Зам тээвэр, харилцаа холбоо	6.24	2.60	307.21	34.59	2.58	70.644
(300) Үйлдвэрлэл	34.23	28.12	38.22	17.59	23.75	28.382
(310) Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загасчлал	17.52	10.78	13.92	12.66	15.75	14.126
(320) Аж үйлдвэр, уул уурхай, барилга	12.06	13.55	23.93	4.69	7.57	12.36
(330) Худалдаа, аялал жуулчлал	4.65	3.79	0.38	0.23	0.43	1.896
(400) Олон салбар	35.39	25.67	26.43	9.16	15.80	22.49
(500)Хөтөлбөрийн дэмжлэг	2.07	11.83	8.26	0.00	285.25	61.482
(700)Хүмүүнлэгийн тусламж	4.76	1.29	0.97	2.13	2.50	2.33

Эх сурвалж : OECD.Stat, (2019)

- (Голлох түншийн дэмжлэг үзүүлсэн байдал) ‘16 -‘17 он дунджаар нийт ODA төвшний шилдэг хандивлагч улс/байгууллагыг харвал Япон улс(345 сая ам.доллар), WB(75 сая ам.доллаар), ADB(35 сая ам.доллар), БНСУ(34 сая ам.доллар) гэсэн дараалалтай байна.



Эх сурвалж : OECD.Stat, (2019)

- Голлох хандивлагч улс/Байгууллага тус бүрийн голлох тусламжийн стратеги доорхтой адил байна.
 - (JICA) МУ-д тусламж үзүүлэх бодлого(Country Assistance Policy for Mongolia) Гол стратеги нь Эрүүл макро эдийн засаг ба хүчтэй засаглал, Байгаль орчинд ээлжтэй, тэнцвэртэй эдийн засгийн хөгжил, Нийгмийн хүртээмжтэй байдал.
 - (ADB) Улс тус бүрт төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө(Country Operations Business Plan; COBP, 2019-2021) гол стратеги нь Эдийн засаг ба нийгмийн тогтвортой байдлыг дэмжих,

Эдийн засгийн олон төрлийн төлөөх үндсэн байгууламжийг сайжруулах, Байгаль орчны тогтвортой байдал бэхжиж, төрийн байгууллагын удирдлага, жөндөрийн тэгш байдлыг харгалзан үзэх.

- **(WB)** Дунд болон урт хугацааны хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах шатандаа явж байгаа бөгөөд улс тус бүрийн хамтын ажиллагааны тогтолцоо(Country Partnership Framework) гол стратеги нь Засаглалыг дэмжих, Өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, Хүний нөөцийг хөгжүүлэх болон уян хатан байдлыг сайжруулах

2) БНСУ-ын ODA дэмжлэгийн өнөөгийн байдал

- Голлох Сүүлийн 5 жилийн хугацаанд дунджаар 17 Яаманд 155.98 ам.долларын буцалтгүй тусламжийг өрнүүлэх
- Нийт буцалтгүй тусламжийн зарлага нь ойролцоогоор 130 сая ам.доллар, хөнгөлөлттэй зээл хэмжээ ойролцоогоор 23сая ам.долларын тусламж үзүүлсэн байна.

(Нэгж : 1 сая ам.доллар)

	2013	2014	2015	2016	2017	Нийт 5 жил
Буцалтгүй тусламж	30.37	32.78	26.14	20.85	20.75	130.89
Хөнгөлөлттэй зээл	-	-	-	20.55	2.54	23.09

Эх сурвалж : OECD.Stat, (2019)

- Салбар тус бүрийн тусламжийн жагсаалт (2017 оны байдлаар)

(Нэгж : 1 сая ам.доллар)

Салбар тус бүр	Нийгмийн Дэд бүтэц	Эдийн засгийн Дэд бүтэц	Үйлдвэрлэлийн салбар	Олон салбар	Бусад
	16.75	2.42	3.84	2.47	0.12
Хувь(%)	65.4	9.5	15.0	9.6	0.5

Эх сурвалж : OECD.Stat, (2019)

- Голлох Сүүлийн 5 жилийн хугацаанд дунджаар 17 Яаманд 155.98 ам.долларын Тусламж үзүүлэгч улс орнууд дундаас 3~4 дүгээр байр эзлэх бөгөөд 1 дүгээр байранд орсон Япон улсаас ойролцоогоор нөлөөллийн хувьд 10 дахин бага байна.
- EDCF тусламжийн (2018-2021/700сая ам.доллар) цар хүрээг өргөжүүлэх төлөвлөгөөтэй байна.

3) KOICA ODA тусламжийн өнөөгийн байдал

- 1991 оноос хойш ойролцоогоор 240 сая ам.долларын тусламжийг үзүүлсэн бөгөөд 2013 оноос хойш жил бүр дунджаар 19.9 сая ам.долларыг тусламж үзүүлсэн байна.

Ангилал	2013	2014	2015	2016	2017
Хэмжээ(1 сая ам.доллар)	25.49	25.98	21.58	13.89	11.01

- Салбар тус бүрээр авч үзвэл боловсрол, төрийн захиргаа, технологи байгаль орчин эрчим хүч, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, загасны аж ахуй гэсэн дараалалтай байна.

В. KOICA ODA төсөл хөтөлбөрийн гол үр дүн ба хязгаарлалт

- **(Ерөнхий үнэлгээ)** 2 дахь шатны CPS-д тусгаснаар тусламж хүлээн авагч улс оронтой бодлогын яриа хэлэлцээр хийх замаар голлох хамтын ажиллагааны салбарын нөөцийн хуваарилалтыг хадгалах(Голлох тусламжийн салбарын гүйцэтгэл 100%). Зам тээврийн салбараас бусад салбарт жигд хүртээмжтэйгээр бүтэцчилэх
 - Голлох тусламж үзүүлэх эрүүл мэнд, боловсролын салбарын нийгмийн үзүүлэлт(Нялхас-Эхийн эндэгдэл, сургуулийн өмнөх боловсролд хамрагдах төвшин, хүйсийн харьцаа) нь өндөр бөгөөд цаашид МУ-ын эдийн засгийн хөгжлийн бодлого(аж үйлдвэрийн төрөлжилт)-ыг дэмжихийн тулд хөдөө аж ахуйн салбарт тусламж үзүүлэх шаардлагатай.
 - Улаанбаатар хот руу чиглэх хүн амын шилжилт хөдөлгөөн ихэссэнтэй холбогдуулан хотыг өөрчлөн байгуулах шаардлагатай.
- **(Төрийн захиргаа)** Монгол улсын цахим засаглалыг бий болгох төсөл хөтөлбөрт түлхүү тусламж үзүүлэх бөгөөд Монгол улсын төрийн захиргааны үр ашгийг дээшлүүлэх үүднээс монгол улсын цахим засаглалын индекс 2014 онл 0.5194 байснаас 2018 онд 0.5824('Very High EDGI') төвшинд хүргэхэд хувь нэмэр оруулах
 - Монгол улсын дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн чадавхыг бэхжүүлэх төсөл (14-18/4 сая ам. доллар)
 - Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг цахимжуулах төсөл(17-19/4

сая ам. доллар)

- Цахим шалган нэвтрүүлэх төслийн дараах дэмжлэг(18-19/360 мянган ам. доллар)
- ГХЯ-ны Гадаад харилцааны төв архивын чадавхыг бэхжүүлэх төсөл('06/330 мянган ам.доллар) Төслийн дараах дэмжлэг(19-20/300 мянган ам. доллар)
- Монгол улсад Уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах менежментийн чадавхыг бэхжүүлэх төсөл(14-19/5 сая 800 мянган ам. доллар)

* Гэвч Монгол улсын төр дахь авилгын төсөөллийн индекс(CPI) нь 2015 онд 167 улс дундаас 72-рт жагсаж байснаас (39/100 оноо) 2018 онд 180 улсаас 124-т (31/100 оноо) жагссанаас харвал Монгол улсын төрийн удирдлагын хөгжүүлэхэд авилгыг бууруулах хүчин чармайлтыг нөөцлөх шаардлагатай байна.

- **(Усны нөөцийн менежмент ба эрүүл ахуй)** Ундны усны аюулгүй хэрэглээний төвшин ба эрүүл ахуйг хангасан орчны хомсдолын улмаас уур амьсгалын өөрчлөлтөд өртөх магадлалтай орон нутгууд(Баянхонгор, Завхан, Говь-Алтай)-д ундны усны аюулгүй байдлыг чанарыг хангасан ундны усаар хангах болон эрүүл ахуй, хүүхдийн хоол тэжээлийг сайжруулах төслийг дэмжих
 - Орон нутгийн иргэдэд түшиглэсэн, уур амьсгалд тэсвэртэй Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ” төсөл (19-21/4.5 сая ам.доллар)
 - Бага насны хүүхдийн хоол тэжээлийн удирдлагыг сайжруулах төсөл(18-20/563 сая вон)
 - Бэлгийн замаар дамжих халдварт өвчнийг хиймэл оюун ухаан ашиглан оношлох төсөл(18-20/500 сая вон)
- **(Мэргэжлийн сургалт ба дээд боловсролыг сайжруулах)** Монгол улсын үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор мэргэжлийн сургалтын тогтолцоог бэхжүүлэх, дээд боловсролын чанарыг сайжруулахад хувь нэмэр оруулах
 - **(Мэргэжлийн сургалтын төсөл)** Мэргэжлийн сургалтын бодлого ба тогтолцоог сайжруулах, Багшийн чадавхыг бэхжүүлэх, Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд үндэслэн сургалтын орчинг сайжруулах зэрэг арга замаар ажилгүйдлийн төвшинг бууруулах, аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах, дээд боловсролын байгууллагуудад мэргэшүүлэх, боловсролын чанарыг

- сайжруулах замаар салбарын хөгжилд хувь нэмэр оруулах
- Монгол Улсын техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөгжүүлэх KOICA болон GIZ-ийн хамтарсан төсөл (19-22/4.5 сая ам.доллар)
 - (Дээд боловсролын төсөл) ICT Дээд боловсрол : Боловсролын чадавхыг бэхжүүлэх, Судалгааны хөгжлийн чадавхыг бэхжүүлэх, Боловсролын орчинг сайжруулах замаар ICT үйлдвэрлэлийн салбарын чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах
 - ШУТИС МХТС-ийн чадавхыг бэхжүүлэх төсөл(19-22/6 сая ам.доллар)
 - (Зам тээвэр) 2 дахь шатны стратеги CPS (2016-2020)-ийн хугацаанд зам тээврийн салбарт глобал сургалтын хөтөлбөрөөр дэмжлэг үзүүлэх. Зам ба төмөр замын системийг сайжруулах төсөл хөтөлбөрийн дэмжлэг байхгүй бөгөөд БНСУ-ын засгийн газрын шинэ умардын бодлогод нийцүүлэн 2021 оны төсөл хөтөлбөрт тусгах
 - ICAO Хамтарсан сургалт-Нисэх буудлын бүтээн байгуулалт ба ашиглалт

III. КОЙКА-гийн дэмжлэг үзүүлэх стратеги

1. SWOT шинжилгээ болон хэрэгжүүлэх хөтөлбөр боловсруулах

Гадаад орчин (Монгол улс/Бусад) (БНСУ/КОЙКА)	Давуу тал	Сул тал
	<ul style="list-style-type: none"> • Хүлээн авагч улсын хөгжлийн хэрэгцээнд нийцсэн технологийн харьцангуй давуу талыг бий болгох, дэмжлэг үзүүлэхэд саадгүй (Соёлын хувьд Солонгосын технологийг нутагшуулах бүрэн боломжтой) • EDCF 2 дахь ээлжийн FA 700 сая ам долларын гэрээ хийгдэж БНСУ-ын ODA буюу хөгжлийн албан ёсны тусламжийн төслийн хэмжээг нэмэгдүүлэн үр өгөөжийг дээшлүүлж байна. • БНСУ-ын ЗГ-ийн хэрэгжүүлж буй шинэ умардын бодлого дахь стратегийн чухал улс (Төмөр зам-Ложистк гм өргөн цар хүрээтэйгээр 	<ul style="list-style-type: none"> • 2 дахь шатны CPS(16-20) Төрийн захиргааны салбар (цахим засаг төсөл) –т онцгойлон дэмжлэг үзүүлсэн • Хэт тархай бутархай дэмжлэг (2019 онд 17 яаманд нийт 38 төсөл) үзүүлснээр төвлөрсөн чанар бүхий үр нөлөө багатай. • N-2 төсөл сонгох тогтолцооны улмаас Монгол улсын засгийн газрын богино хугацааны хөгжлийн бодлогыг тусгахад дутагдалтай бөгөөд энэ нь төслийн тогтвортой

ODA төслийн хэмжээг нэмэгдүүлэх хандлагатай)

• CPS 1-2 дахь шатанд хэрэгжүүлсэн төслийг үргэлжлүүлэн төслийн үр дүнг нэмэгдүүлнэ.

хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй.

• Хөтөлбөрийн стратеги байхгүй, төсөл хоорондын уялдаа дутмаг

• Олон донор байгууллагуудын үйл ажиллагаагаар дамжуулан олон талт хамтын ажиллагааг хэрэгжүүлэх

• 2 дахь шатны CPS – ийг дүгнэх, 3 дахь шатны CPS(21-25) –ийг боловсруулах

• Гуравдагч хөршийн хувьд шинэ умардын бодлогыг дэмжигч улс (Далайд гарцтай болох боломжийг эрэлхийлж байгаа)

• ODA –ээр дамжуулан ЭЗ-гийн хөгжил, аж үйлдвэрийн олон талт бодлогыг хэрэгжүүлэх (LMIC→UMIC шилжих)

SO Стратеги

• (Богино хугацаанд) шинэ умардын бодлого дахь ложистик болон зам тээврийн салбарын төслийг дэмжих (Богино хугацаанд)

Тогтолцоо болон систем бий болгох, боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх замаар төрийн захиргааны салбарын төслийг дэмжих (БНСУ-д сургалтад хамруулах, сайн дурын гишүүн томилох гм)

• (Дунд хугацаанд) Олон талт/ хоёр талт хамтын ажиллагааг өргөжүүлэн нөү хау, туршлага хуваалцах, нөлөөлийг нэмэгдүүлэх

WO Стратеги

• (Дунд хугацаанд) ЭСЯ төвтэйгөөр хөгжлийн албан ёсны тусламжийн зөвлөлдөх сувгийг идэвхжүүлэхийн төлөө ажиллах,

• (Богино хугацаанд) 2019 CP – д тулгуурлан хөтөлбөр хоорондын уялдаа холбоог сайжруулах(хоёр талт хамтын ажиллагаа-Глобал сургалт - WFK гм)

• (Дунд хугацаанаад) Өргөн цар хүрээг хамруулсан хоёр талт хамтын ажиллагааны төслийг хэрэгжүүлэх, уялдааг сайжруулан эдийн засгийн хөгжлийг дэмжих шууд бус дэмжлэг

Боломж

О

Аюул

Т

- ОУВС-гийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдан (2017.5) төсвийн зарцуулалтыг танаж эхэлсэн.
- Уул уурхайд түшиглэсэн ЭЗ-ийн хөгжил нь(экспортын 86.6%) гадаад зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлтөд эмзэг
- УИХ-ын(20 он), Ерөнхийлөгчийн(21 он) сонгуулийн дүнгээс хамаарч улс төрийн нөхцөл байдал болон үндэсний хөгжлийн бодлого өөрчлөгдөх магадлалтай
- Зах зээлийн эдийн засаг/Ардчилсан тогтолцоонд шилжээд удаагүй байгаа тул засаг захиргааны тогтолцоо тогтворгүй
- Улаанбаатар хотын хүн амын хэт төвлөрөл

- (Богино хугацаанд) Засаглалыг сайжруулах зорилгоор цахим засагт чиглэсэн төслийн хувь харьцааг бууруулж хуулийн тогтолцооны хүртээмж болон улс төрийн тогтолцоог сайжруулах төслийг нэмэгдүүлэх
- (Дунд хугацаанд) Хэт уул уурхайд түшиглэсэн байдлыг халах үүднээс эдийн засгийн олон талт салбар руу чиглэсэн төслийг дэмжих
- (Дунд хугацаанд)Хот байгуулалт болон нөхөн сэргээгдэх чадавхыг дэмжих төслийг дэмжих

- (Богино хугацаанд)2019-2020 СР-г боловрсуулан 3 дахь ээлжийн CPS(21-25)-д урьдчлан бэлдэх
- (Дунд хугацаанд) Хэрэгжүүлэх төслийг нээн илрүүлэх тогтолцоог нутагшуулан Монгол улсын хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн төслийг тусгах
- (Дунд хугацаанд) Буцалтгүй тусламжийн үндсэн хэлэлцээрээр дамжуулан тогтвортой төслийг хэрэгжүүлэх суурь бий болох
- (Дунд хугацаанд) Монгол улсын ЭЗ-ийн хөгжлийн бодлого болон хөгжлийн орчинд нийцүүлэн 3 дахь CPS(21-25)-ийн дэмжлэг үзүүлэх гол салбарыг өөрчлөх (Хот байгуулалт, газар тариалан, зам тээвэр гм)

Хэрэгжүүлэх хөтөлбөр

- **(Зам тээвэр)** Ложистик дэд бүтэц, зав тээврийн аюулгүй байдлыг сайжруулах
- **(Хот байгуулалт)** Тогтвортой хот байгуулалт болон нөхөн сэргээгдэх чадавхыг бэхжүүлэх
- **(Хөдөө аж ахуй)** Хүртээмжтэй хөдөө аж ахуйг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний аюулгүй байдлыг сайжруулах
- **(Төрийн захиргаа)** Засаглалыг сайжруулах замаар тогтвортой хөгжлийг дэмжих

2. Хэрэгжүүлэх хөтөлбөр

- 2-р CPS дахь амжилттай хэрэгжсэн салбарт төслийг үргэлжлүүлэх(ТЗУ)
- 2-р CPS дахь шинэ умардын бодлогод нийцсэн төслийг үргэлжлүүлэх(ЗТ)
- 2-р CPS дахь үр дүн багатай салбарыг хасах(боловсрол, эрүүл мэнд)
- Монгол улсын хөгжлийн бодлого, засгийн газрын мөрийн хөтөлбөрт нийцсэн төслийг хамруулах(Хот байгуулалт, хөдөө аж ахуй)

(1) Ложистик дэд бүтэц, зам тээврийн аюулгүй байдлыг сайжруулах/шинэ умардын бодлого, SDG11

□ Үндсэн чиглэл

- Өргөн хүрээтэй эдийн засгийн болон нийгмийн хөгжлийн төлөөх тогтвортой хөгжлийн зорилтууд(SDGs) ын нэг зам тээврийн салбар дахь шууд болон шууд бус зорилтын биелэлтэд хувь нэмэр оруулах
 - * SDG 3.6 –д тусгасан зам тээврийн аюулгүй байдлыг сайжруулах, 7.3-т тусгасан эрчим хүчний (зам тээвэр) үр ашгийг нэмэгдүүлэх, 9.1-т тусгасан зам тээврийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, 11.2-т тусгасан тогтвортой хөгжих зам тээврийн системийг бий болгох,, 11.2-т тусгасан тогтвортой хөгжих зам тээврийн системийг өргөжүүлэх, 12.С хатуу түлшнээс татаас авах тогтолцоог сайжруулах гм
- ‘КОЙКА’-гийн зам тээврийн салбар дахь дунд хугацааны стратеги (2016-2020)’ стратегийн зорилт, дэлгэрэнгүй гаргасан хөтөлбөрт нийцүүлэх, үр дүнг тооцох загвар ашиглах
- ‘Шинэ умардын бодлого’ дахь Монгол улсын зам тээврийн хүртээмжтэй байдал, уялдаа зэргийг дээшлүүлснээр эдийн засгийн болон ложистик аж үйлдвэрийн хөгжлийг хурдасгаж, аюулгүй, байгальд ээлтэй зам тээврийн системийг бий болгоход хувь нэмэр оруулах
- Зам тээвэр болон ложистикийн салбар дахь KSP-ийн төсөлтэй уялдах төслийг бий болгох
- (Үргэлжлэх төсөл) Зам тээврийн салбарт глобал сургалт болон сайн дурын гишүүн томиллох төслийг хэрэгжүүлэх

□ Стратеги зорилт / хөтөлбөр

Стратеги зорилт	хөтөлбөр
1.Зам тээврийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, ЭЗ-ийн аж үйлдвэрийн хөгжлийг дэмжих	<ul style="list-style-type: none">▪Улсын болон орон нутгийн зам тээврийн/төмөр зам, агаарын тээвэр/ хөгжлийн мастер төлөвлөгөө боловсруулах, ТЭЗҮ гаргах▪Авто замыг нөхөн сэргээх, гүүр, хоолой гаргах мастер төлөвлөгөө боловсруулах, ТЭЗҮ гаргах▪ Авто замын гэрлэн дохионы системийг шинэчлэх▪ Авто болон төмөр замын нэгдсэн удирдлагын системийг шинэчлэх

2. Байгальд ээлтэй, аюулгүй зам тээврийн системийг бий болгоход дэмжлэг үзүүлэх	<ul style="list-style-type: none"> ▪ Хотын авто замын системийг сайжруулах мастер төлөвлөгөө ▪ Хотын авто замын байгууламжийг сайжруулах ТЭЗҮ гаргах, туршилтын хөтөлбөр хэрэгжүүлэх ▪ Ухаалаг зам тээврийн систем (ITS) бий болгох, хотын замын хөдөлгөөний ачааллыг бууруулах ▪ Зам тээврийн суурь төлөвлөгөөг гаргах, зам тээврийн аюулгүй байдлын чадавхыг бэхжүүлэх, зам тээврийн байгууламжийн аюулгүй байдлыг сайжруулах гм
---	--

□ Үндсэн үзүүлэлт (Outcome/Output)

Стратеги зорилт	Үр дүн	Гаралт
1. Зам тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ЭЗ-ийн аж үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	<ul style="list-style-type: none"> ▪ Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дотоод хөрөнгө оруулагчийг татах ажлыг зохион байгуулах ажил (уулзалт гм) ▪ Дотоод болон гадаад худалдааны эргэлт нэмэгдэх, борлуулалтын хугацаа болон зардал багассан хувь хэмжээ 	<ul style="list-style-type: none"> ▪ Мастер төлөвлөгөө, ТЭЗҮ, хэрэгжүүлэх зураг төслийн тайлан ▪ Орчин үеийн нэгдсэн удирдлагын систем
2. Байгаль орчинд ээлтэй аюулгүй зам тээврийн систем бий болгоход дэмжлэг үзүүлэх	<ul style="list-style-type: none"> ▪ Зам тээврийн ослоос улбаалсан нийгэм эдийн засгийн хохирлын хэмжээ ▪ Замын хөдөлгөөний нягтаршил, бөөгнөрөл ▪ Нүүрстөрөгчийн давхар исэл ялгаруулах хэмжээ, агаарын бохирдлын хэмжээ 	<ul style="list-style-type: none"> ▪ Мастер төлөвлөгөө, ТЭЗҮ, хэрэгжүүлэх зураг төслийн тайлан ▪ Зам тээврийн аюулгүй байдлыг хангах байгууламж (явган хүний гарц, хажуугийн хашлага, тусгаарлах хаалт, дугуйн зам, явган хүний зам гм)

□ Гол төслүүд

- (Төлөвлөж байгаа) Төмөр замын нэгдсэн удирдлагын төвийн (TRCC) чадавхыг бэхжүүлэх, TMGR давхар эгнээ зам барих ТЭЗҮ-ийн судалгаа (21-25/15 сая ам доллар)
- (Төлөвлөж байгаа) Зам тээврийн аюулгүй байдлын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, байгууламж барих төсөл(судалж байгаа)
- (Төлөвлөж байгаа) 2019 оны Солонгосын санхүү төлөвлөлтийн яамны KSP төслөөр хэрэгжиж буй зам тээвэр-ложистик салбарын төслийн үр дүнтэй танилцан түүнтэй уялдаатай төслийг бий болгох
 - Тогтвортой хөгжих төмөр замын салбарын хөгжлийн төлөөх суурь төлөвлөгөөг гаргах
 - Агаарын тээврийн салбар дахь 2025 мастер төлөвлөгөөг боловсруулах

- Зам тээврийн салбарын нэгдсэн системийг бий болгох чиглэл

- (Хэрэгжиж байгаа) Зам тээврийн салбарт глобал сургалт, сайн дурын гишүүн томилох төсөл

□ **Дотоод гадаадын байгууллагатай хийх хамтын ажиллагааны чиглэл**

- (Дотоод) Санхүү төлөвлөлтийн яам (KDI), Газар нутаг, зам тээврийн яам, KORAIL, Төмөр замын байгууламжийн аюулгүй ажиллагааны корпораци, Зам тээврийн аюулгүй ажиллагааны корпораци, эрдэм шинжилгээний салбар, Техник, технологийн чиглэлийн аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах
- (Гадаад) Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж буй АХБ зэрэг байгууллагуудтай зам тээврийн салбарт хэрэгжүүлж буй төслийн талаарх мэдээллээ хуваалцаж төслийн уялдаа холбоог сайжруулан синержи эффект бий болгох

(2) Тогтвортой хот байгуулалт, нөхөн сэргээгдэх чадавхыг бэхжүүлэх

□ **Үндсэн чиглэл**

- ‘SDG 11 (тогтвортой хот байгуулалт) дэх зорилтод хүрэхийн төлөөх аюулгүй зам тээврийн тогтолцоо, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хаягдал болон агаарыг бохирдуулагч бодисын талаарх хяналт удирдлагыг сайжруулах, иргэдийн оролцоотой нэгдсэн, тогтвортой хөгжих хот байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах
- Улаанбаатар хотын хүн амын өсөлт, хэт төвлөрөлтийн улмаас ундны ус болон эрүүл ахуйн байгууламжийн хүртээмж дутмаг, өвлийн улиралд дулаан хангамж хүрэлцээгүй, ахуйн хог хаягдал нэмэгдэж байгаа зэрэг асуудлыг шийдэх үүднээс ахуйн орчинг сайжруулахад хувь нэмэр оруулах

* Хамтын ажиллагаатай улс орны хэт төвлөрлийг бууруулах үүднээс хотыг тэлэх, хот байгуулалтын стратеги төлөвлөгөө боловсруулах, нийтийн хэрэгцээний бараа үйлчилгээгээр хангах зэрэг олон салбар дамжсан уялдааг бий болгох

□ **Гол стратеги зорилт болон хөтөлбөр**

Стратеги зорилт	Хөтөлбөр
-----------------	----------

1. Ухаалаг шийдлээр цэвэрхэн, тогтвортой хөгжих орчин бүхий хотыг бий болгох	<ul style="list-style-type: none"> ▪ Нийтлэг хүртээмжийг дээшлүүлэх, усны орчны удирдлагыг сайжруулснаар цэвэр усны хангамжийг тогтворжуулах ▪ Бага орлоготой давхаргад зориулж орон сууцжуулах төлөвлөгөөг боловсруулах гм ▪ Хүлэмжийн хийг бууруулах, цаг уурын өөрчлөлтөд зохицох төслийг нэмэгдүүлэх
2. Хотын асуудлыг шийдэх, бүс нутгийн нөхцөл байдалд тулгуурлан асуудлыг шийдэх	<ul style="list-style-type: none"> ▪ Хог хаягдлын менежментээр дамжуулан хотын нөхөн сэргээгдэх чадавхыг бэхжүүлэх ▪ Эрчим хүчний хангамж дутмаг давхаргын эрчим хүчний хүртээмжийг нэмэгдүүлэх ▪ Агаарын бохирдол үүсгэгч бодисыг бууруулах төлөвлөгөө боловсруулах

□ Гол үзүүлэлт (Outcome/Output)

Стратеги зорилт	Үр дүн	Гаралт
1. Ухаалаг шийдлээр цэвэрхэн, тогтвортой хөгжих орчин бүхий хотыг бий болгох зорилтод хүрэх	<ul style="list-style-type: none"> ▪ Аюулгүй, цэвэр ундны усаар хангагдах хувь хэмжээ ▪ Агаар дахь хүлэмжийн хийн тогтвортой үзүүлэлт 	<ul style="list-style-type: none"> ▪ 1 өдөр 1 хүн 20 литр цэвэр усаар хангагдах боломжтой хүний тоо ▪ Жилд ялгарах хүлэмжийн хийн (CO₂) багассан тоо, хэмжээ(tons CO₂-eq)
2. Хотын асуудлыг шийдэх, бүс нутгийн нөхцөл байдалд тулгуурлан асуудлыг шийдэх	<ul style="list-style-type: none"> ▪ Хаягдал устгах, дахин боловсруулах тоног төхөөрөмж, байгууламжийн нийлүүлэлт ▪ Тогтолцоог хуульчлах, засгийн газрын бодлогод тусгагдсан эсэх 	<ul style="list-style-type: none"> ▪ Шинээр болон сэргээсэн хаягдал устгах, дахин боловсруулах тоног төхөөрөмж, байгууламжийн тоо ▪ Сэргээгдэх эрчим хүчний мастер төлөвлөгөө

□ Гол төсөл

- (Хэрэгжиж байгаа) КОЙКА болон НУБ-ын Хүүхдийн Сангаас “Орон нутгийн иргэдэд түшиглэсэн, уур амьсгалд тэсвэртэй Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ” төсөл (‘19-’22/4,500 мянган ам доллар)
- (Хэрэгжиж байгаа) Цаг уурын өөрчлөлтөд тэсвэртэй тогтвортой усны удирдлага, хот байгуулалтын бодлогын чадавх бэхжүүлэх, эрчим хүчний бодлогын чадавх бэхжүүлэх, цаг уурын өөрчлөлтийн талаар авч хэрэгжүүлэх бодлого
- (Хэрэгжиж байгаа) Хот байгуулалтын салбарт глобал сургалтын төсөл болон сайн дурын гишүүн томилох төсөл
- (Төлөвлөж байгаа) Хот байгуулалтын мастер төлөвлөгөө боловсруулах төсөл

□ **Дотоод гадаадын байгууллагатай хийх хамтын ажиллагааны чиглэл**

- EDCF сангийн төсөлтэй уялдуулах чиглэлийг тодорхойлох ; 10 аймагт орон нутгийн дулаан хангамжийн системийг сайжруулах төсөл (148,720 мянган ам доллар), агаарын чанарыг сайжруулах хөтөлбөр(хөнгөлөлттэй зээл 60 сая ам доллар), Орон сууцжуулах төсөл(эцэслэн шийдэгдээгүй) гм
- UNDP, UNICEF, ADB зэрэг байгууллагуудаас хэрэгжүүлж байгаа төслүүд болон хот байгуулалтын дэд хөтөлбөртэй уялдуулах

(3) Хүртээмжтэй хөдөө аж ахуйг хөгжүүлэх, газар тариалангийн бүтээгдэхүүний аюулгүй байдлыг сайжруулах /SDG2

□ **Үндсэн чиглэл**

- SDGs Хөдөө аж ахуйн бүтээмжийн чадамжийг сайжруулах зорилтыг хангах үүднээс тогтвортой хөдөө аж ахуй, газар тариаланг хөгжүүлэх төслийг дэмжих
* SDG 2 : Шим тэжээлийн дутагдлыг арилгах, хүнсний аюулгүй байдлыг хангах, тогтвортой хөдөө аж ахуйн хөгжлийг бэхжүүлэх
- Хэт уул уурхайд түшиглэсэн байдлыг халах үүднээс эдийн засгийн олон талт салбар руу чиглэсэн Монгол улсын засгийн газрын бодлогод нийцүүлэн хоёр дахь аж үйлдвэр болох хөдөө аж ахуйн салбар дахь төслийг түлхүү дэмжих
- ‘КОЙКА-гийн хөдөө орон нутгийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги (2016-2020)’ стратеги зорилт, дэлгэрэнгүй хөтөлбөрт нийцүүлэх, үр дүнгийн үзүүлэлтийн хүснэгт ашиглах

□ **Стратеги зорилт болон хэрэгжүүлэх хөтөлбөр**

Стратеги зорилт	Хөтөлбөр
1. Тогтвортой хөдөө аж ахуйн бүтээмжийг дээшлүүлэх, зах зээлийг өргөтгөх	<ul style="list-style-type: none"> ▪ Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн суурийг бий болгох, бүтээмжийг нэмэгдүүлэх(сайн чанарын сорс судлах, нийлүүлэх, тариалангийн тоног төхөөрөмж нийлүүлэх, эрчимжүүлсэн мал аж ахуйн техникийг нутагшуулах гм) ▪ Хөдөө аж ахуй эрхлэгчдийн чадавхыг бэхжүүлэх(бүтэц зохион байгуулалтад оруулах, орлогыг нэмэгдүүлэх, салбарын боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх гм) ▪ Хөдөө аж ахуйн зах зээлийг нэмэгдүүлэх(хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн дараах менежмент, нэмүү өртгийг шингээх гм)

<p>2. Уур амьсгалын өөрчлөлт эсрэг авах арга хэмжээний хүрээнд газар тариалан, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн систем болон байгалийн баялагийг хамгаалах</p>	<ul style="list-style-type: none"> ▪ Ой модны нөөцийг хамгаалах, ой хээрийн бүсийн ойролцоо мод үржүүлэх аж ахуйг хөгжүүлэх (ургамал сэргээх, мод тарих гм) ▪ Газар тариалан, мал аж ахуйн экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, нөхөн сэргээх(Тогтвортой үйлдвэрлэл -борлуулалт-хэрэгцээ, органик бүтээгдэхүүний батламж гм)
<p>3. Газар тариалан, мал аж ахуйн бүтээгдэхүүний тогтвортой байдлыг сайжруулах</p>	<ul style="list-style-type: none"> ▪Хүнсний аюулгүй байдлын тухай хууль, тогтолцоо боловсронгуй болох ▪ Хөдөө аж ахуйн зохистой дадал (GAP) болон хүнсний аюулгүй байдлын тогтолцоо(НАССР) зэрэг хүнсний аюулгүй байдлын стандартын тогтолцоо сайжрах ▪Хүнсний лабораторийн шинжилгээ судалгааны чадавч бэхжих ▪ Газар тариалан, мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулалт, борлуулалтыг орчин үеийн чиг хандлагад хүргэх ▪ Малын гаралтай өвчнөөс урьдчилан сэргийлж өвчин дэгдэлт багасах

Стратеги зорилт	Үр дүн	Гаралт
<p>1. Тогтвортой хөдөө аж ахуйн бүтээмжийг дээшлүүлэх, зах зээлийг өргөтгөх</p>	<ul style="list-style-type: none"> ▪Хөдөө аж ахуйн салбар дахь ЗГ-н төсөв ▪Газар тариалан, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бүтээмж(бөөний болон, жижиглэн худалдааны зах зээлийн үзүүлэлт) 	<ul style="list-style-type: none"> ▪Нийлүүлэгдсэн техник болон технологийн тоо ▪Нэр төрлийн тоо хэмжээ(шинэ бүтээгдэхүүн Т/га мөн малын үүлдрийн нэр төрөл гм) ▪Бөөний төв
<p>2. Уур амьсгалын өөрчлөлт эсрэг авах арга хэмжээний хүрээнд газар тариалан, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн систем болон байгалийн баялгийг хамгаалах</p>	<ul style="list-style-type: none"> ▪ Ойн бүс нутгийн хэмжээ ▪Байгальд ээлтэй газар тариалан, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ 	<ul style="list-style-type: none"> ▪ Ургамал бүхий газар нутаг ▪Тогтвортой үйлдвэрлэл-борлуулалт- хэрэглээний нэгдсэн систем
<p>3 Газар тариалан, мал аж ахуйн бүтээгдэхүүний тогтвортой байдлыг сайжруулах</p>	<ul style="list-style-type: none"> ▪Үйлдвэрлэлийн болон борлуулалтын дамжлагад олон улсын хүнсний аюулгүй байдлын стандартыг дагаж мөрдөх ▪Малын гаралтай өвчин 	<ul style="list-style-type: none"> ▪Үйлдвэрлэл, борлуулалтын дамжлагад халдвар авахаас сэргийлэх удирдлагын тогтолцоо ▪GAP, НАССР зэрэг хүнсний аюулгүй байдлын стандартын

	илэрсэн тоо	тогтолцоог сайжруулан итгэмжлэл шинээр авсан нэгжийн тоо ▪Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх систем
--	-------------	---

□ **Гол үзүүлэлт (Outcome/Output)**

□ **Гол төсөл**

- (Хэрэгжиж байгаа) Хөдөө аж ахуйн нэгдлээр дамжуулан орлогыг нэмэгдүүлж ядуу малчин өрхийн чадавхыг бэхжүүлэх төсөл (18-20/6,850 мянган ам доллар)
- (Хэрэгжиж байгаа) Ноолурын аж үйлдвэрийн тогтвортой хөгжил төсөл (18-19/500 сая вон)
- (Хэрэгжиж байгаа) Цаг уурын өөрчлөлтөөс хохирол амсаж буй бүс нутагт жимс ногооны аж ахуйг хөгжүүлэн иргэдийн бие даах чадварыг бий болгох төсөл (19-21/1,424 сая вон)
- (Хэрэгжиж байгаа) Хөдөө аж ахуйн салбарт глобал сургалт явуулах, сайн дурын гишүүн томилох төсөл
- (Төлөвлөж байгаа) Газар тариалан, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний аюулгүй байдлын менежментийн чадавхыг бэхжүүлэх 2-р төсөл
- (Төлөвлөж байгаа) Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх систем бий болгох чиглэлийн FAO болон EU хамтарсан төсөл

□ **Дотоод гадаадын байгууллагатай хийх хамтын ажиллагааны чиглэл**

- (Дотоод) Хүнс газар тариалан, далайн яам, Ойн агентлаг, Хөдөө тосгоны хөгжлийн яам (KOPIA) зэрэг байгууллагуудын хамтын ажиллагаа
- (Гадаад) Монгол дахь FAO, WFP зэрэг байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх

(4) Засаглалыг сайжруулан тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах/SDG16

□ **Үндсэн чиглэл**

- SDGs буюу тогтвортой хөгжлийн зорилго 16-д заасан зорилгод хүрэхэд хувь нэмэр оруулах үр дүнтэй, хүртээмжтэй засаглалыг бий болгох төсөлд дэмжлэх үзүүлэх
- * SDG 16 : Тогтвортой хөгжлийн төлөөх амар амгаланг цогцлоосон нийгмийн дэвшил болон хүн бүрт хүртээмжтэй хуулийн тогтолцоо болон бүх төвшинд үр дүнтэй, хариуцлагатай хүртээмж өндөр тогтолцоог бий болгох

- Монгол улсын засгийн газрын ‘Урт хугацааны хөгжлийн бодлого (2015-2040)’ болон ‘Тогтвортой хөгжлийн зорилго 2030’ зэрэгт хүлээн авагч улсын засгийн газрын засаглалыг сайжруулахтай холбоотой бодлогын зорилтод нийцсэн төслийг дэмжих
 - * Урт хугацааны хөгжлийн бодлого(2015-2040), Үндсэн бодлогын чиглэл 2 : Засаг захиргааны чадавх болон бодлого, журмыг сайжруулах
 - * Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилт 2030, зорилт 10 : Мэргэжлийн болоод тогтвортой оролцоо бүхий засаглалыг бий болгох, хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд бүхий л төвшинд авлигыг таслан зогсоох
- КОЙКА’-гийн төрийн захиргааны салбар дахь дунд хугацааны стратеги (2016-2020)’ стратегийн зорилт, дэлгэрэнгүй гаргасан хөтөлбөрт нийцүүлэх, үр дүнг тооцох загвар ашиглах
- Өргөн цар хүрээнд хөтөлбөр(төсөл) тус бүртэй холбоотой хууль, эрх зүйн тогтолцоо, засаглалыг сайжруулан хөгжлийн хөтөлбөрийн үр дүнг нэмэгдүүлэх

□ Стратеги зорилт болон хөтөлбөр

Стратеги зорилт	Хөтөлбөр
1. Төрийн үйлчилгээний үр нөлөөг нэмэгдүүлэх	<ul style="list-style-type: none"> ▪ Урьд хэрэгжүүлсэн цахим засаг төслийн системийн бүрэн бүтэн байдал болон систем хоорондын уялдааг дээшлүүлж төрийн үйлчилгээний үр нөлөөг сайжруулах ▪ Сайн чанарын үйлчилгээгээр хангах, тогтвортой байлгах, боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх, засаг захиргааны үр өгөөжийг нэмэгдүүлэх
2. Хууль, тогтолцооны хүртээмжийг дээшлүүлэх	<ul style="list-style-type: none"> ▪ Холбоотой хууль, тогтолцоог шинээр боловсруулан эмэгтэйчүүд болон эмзэг давхаргын хүний эрх, иргэний эрх, нийгмийн эрхийг хамгаалах(Сургалтанд хамрагдаж буй албан хаагчдын 30% эмэгтэй) улс төр дахь эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх гм) ▪ Энх тайван, амар амгаланг цогцлоосон нийгмийн бий болгох үүднээс гэмт хэрэгтэй тэмцэж, хэв журмыг сахиулах чадавхыг бэхжүүлэх(Шүүх шинжилгээ, мэргэшсэн мөрдөн шалгах ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт явуулах гм)

□ Гол үзүүлэлт (Outcome/Output)

Стратеги зорилт	Үр дүн	Гаралт
1. Төрийн үйлчилгээний өгөөжийг дээшлүүлэх	<ul style="list-style-type: none"> ▪ Бодлогод тусгаснаар хууль эрх зүйн орчинг сайжруулснаар төрийн үйлчилгээний чанар нэмэгдэх ▪ Тухайн системийн ашиглалтын үзүүлэлт, үр өгөөж 	<ul style="list-style-type: none"> ▪ Цахим засгийн мастер төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөө, засгийн газрын бодлогод тусгагдсан эсэх ▪ Сайжруулсан систем ▪ IT-гийн сургалтын программ-д

	<ul style="list-style-type: none"> ▪ Систем ашигласнаар хэмнэгдсэн цаг хугацаа, буурсан зардлын хэмжээ ▪ Мэдээллийн нууцлал, систем болон ИТ хариуцсан мэргэжилтний чадавх дээшилснээр нэмэгдсэн ажлын бүтээмж 	<p>суралцсан хүмүүсийн тоо</p> <ul style="list-style-type: none"> ▪ Шинээр сургасан болон/чадавх нь дээшилсэн ИТ –гийн мэргэжилтнүүдийн тоо
2. Хууль эрхзүйн тогтолцооны хүртээмжийг дээшлүүлэх	<ul style="list-style-type: none"> ▪ Эмэгтэй улс төрчдийн улс төр дахь оролцоог дээшлүүлэх ▪ Холбогдох байгууллагын чадавхыг бэхжүүлэн хүлээн авагч улсын/Монгол/ амгалан тайван байдлыг хангах, иргэдийн хуулийн байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлэх 	<ul style="list-style-type: none"> ▪ Улс төр дахь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх хууль эрх зүйн орчин ▪ Джитал шүүх шинжилгээ · мансууруулах бодис · ДНК шинжилгээнд зориулсан төхөөрөмж, лаборатори ▪ Шүүх шинжилгээний мэргэжлийн сургалтад хамрагдсан шинжээч нарын тоо

□ Гол төслүүд

- (Дууссан) Монгол улсын дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн чадавхыг бэхжүүлэх төсөл (14-18/4сая ам доллар)
- (Дууссан)Цахим шалган нэвтрүүлэх төслийн дараах дэмжлэг(18-19/360 мянган ам доллар)
- (Хэрэгжиж байгаа)Уул уурхайн бохирдлын менежментийн мастер төлөвлөгөө боловсруулах, чадавхыг бэхжүүлэх төсөл(14-20/5,800 мянган ам доллар)
- (Хэрэгжиж байгаа) Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг цахимжуулах төсөл (17-19/4 сая ам доллар)
- (Шинэ) ШШҮХ-гийн чадавхыг бэхжүүлэх төсөл (20-23/7 сая ам доллар)
- (Шинэ) Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл (20-22/8 сая ам доллар)
- (Төлөвлөж байгаа)UNDP Эмэгтэй улс төрчдийн чадавхыг бэхжүүлэх төсөл (21-24/7 сая ам доллар)

□ Дотоод гадаадын байгууллагатай хийх хамтын ажиллагааны чиглэл

- (Дотоод) Солонгосын уул уурхайн нөхөн сэргээлтийн корпораци, Шүүх шинжилгээний хүрээлэн зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах
- (Гадаад) Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг UNDP зэрэг байгууллагуудтай

хамтын ажиллагаагаа өргөтгөх